

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал.....	7
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	9
2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	9
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	18
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	18
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	20
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ ХАМГААЛАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	29
БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000017333 дугаартай 4.9 га газрын булангийн цэгүүд	3
Хүснэгт 2. Талбайн хамрах хүрээ, байршил	7
Хүснэгт 9. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	18
Хүснэгт 10. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	20
Хүснэгт 11. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ.....	21
Хүснэгт 12. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт 13. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	26
Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	31
Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны зураг	4
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг	5
Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг	6
Зураг 4. Төслийн талбайн фото зураг №1	7
Зураг 5. Төслийн талбайн фото зураг №2	7
Зураг 6. Төслийн талбайн районы д.т.д өндөршлийн зураг (метр).....	10
Зураг 7. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)	11
Зураг 8. Улаанбаатар хотын уур амьсгалын горим	12
Зураг 9. Салхины хурдны жилийн явц	13
Зураг 10. Салхины зүгийн давтагдал улирлаар (НЗДТГ, 2018)	13
Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн өөрчлөлт.....	14
Зураг 12. Төслийн талбайн районы гадаргын усны зураг	15
Зураг 13. ОХШХ-ийн зураг	30

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Хаягдал яс, өөх болон дайвар боловсруулах үйлдвэр” төсөл

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

- “Монгол Нью Ресурс Технологи” ХХК
- Хувийн хэргийн дугаар: 9019087113
- Регистрийн дугаар: 6293905

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас

- Улаанбаатар, Сонгинохайрхан, 32-р хороо, Эмээлт 18400, Үйлдвэрлэлийн бүс
- Утас: 976-89017777

Компанийн хэлбэр

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Байгуулагдсан он

- 2018.04.03

Харьяалал

- Монгол

Төслийн байршил:

“Монгол Нью Ресурс Технологи” ХХК-ийн төслийн талбай нь засаг захиргааны хуваариар Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэр, Эмээлт уулын зүүн энгэрт, Улаанбаатар хотын төвөөс 35 км зайд байрлана.

- Талбайн хэмжээ: 4.9 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-48-10


Газарзүйн солбицол:

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000017333 дугаартай 4.9 га газрын булангийн цэгүүд


№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	106	35	57.94	47	51	39.62
2	106	35	53.14	47	51	41.45
3	106	35	59.61	47	51	50.86
4	106	36	7.83	47	51	47.09



Зураг 1. Засаг захиргааны зураг



Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршилн зураг



Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал

Тус төслийн зорилго нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх замаар олон улсын жишиг, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын малын гаралтай хаягдал яс, өөх, дайврыг бүрэн боловсруулан ясны уураг, ясны тос өөхөн тос, ясны үнс зэргийг үйлдвэрлэн Хятад улс руу экспортлох, Үүнд: Ясны уураг нь эмийн үйлдвэрт, ясны тос, өөхөн тос нь ахуй хэрэгцээ савангийн үйлдвэрт, харин ясны үнсийг гангар шаазангийн үйлдвэрт, тосны шимэлдэг нь бордооны үндсэн түүхий эдээр ашиглагдах юм. Цаашлаад эдгээр түүхий эдээр дотооддоо ясны гурил, шаазан эдлэл, саван, шампунь, цэвэрлэгээний бодис зэргийг үйлдвэрлэх зорилготой.

Хүснэгт 2. Талбайн хамрах хүрээ, байршил

Хот	Дүүрэг, хороо	Талбайн хэмжээ (м ²)
Улаанбаатар	Сонгинохайрхан, 32-р хороо	49960.0



Зураг 4. Төслийн талбайн фото зураг №1



Зураг 5. Төслийн талбайн фото зураг №2

Төслийг хэрэгжүүлэгчийн тухай “Монгол Нью Ресурс Технологи” ХХК нь 2018 оны 4-р сард үүсгэн байгуулагдсан бөгөөд гадаад худалдаа, яс, тос боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Төслийн зорилго нь малын гаралтай хаягдлыг технологийн дагуу тухайн худалдан авагчид шаардлага хангасан түүхий эдийг нийлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ ажлын байр бий болгох, шинэ техник технологи нэвтрүүлэх, органик бүтээгдэхүүн амьдралын баталгаа зорилтуудыг хэрэгжүүлэн ажилчин албан хаагчдын бодит орлого нэмэгдүүлж олон улсын стандартын шаардлага хангасан ясны уураг, ясны үнс, тос зэргийг үйлдвэрлэж хаягдал ясны гаралт бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэн ажиллана.

“Монгол Нью Ресурс Технологи” ХХК нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутагт “Хаягдал яс, өөх тос, дайвар боловсруулах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэх юм. Ийнхүү үйлдвэрийн газар нь аж ахуйн зориулалттай газар болно. Нийт газрын хэмжээ 50000 м/кв талбайтай үйлдвэрийн хашаандаа одоогийн 7250 м/кв талбайд барилга байгууламж баригдсан байна. Тус үйлдвэр нь хаягдал яс, өөх тос дайвар боловсруулах юм. 1 өдөрт дунджаар 30 тн хаягдал яс чанаж боловсруулах бөгөөд 5 тн ясны тос, 15 тн цагаан яс үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд улирлаас хамааран хэлбэлзэнэ. Төслийн үндэслэл Монгол улсад яс цуглуулах, ясаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх зах зээл нь төдийлөн хөгжөөгүй салбар бөгөөд маш бага хэмжээний, нийт хаягдал ясны 10-15 хувь орчмыг дахин боловсруулж, түүгээр кальцийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, илүүдэл буюу дотоодын хүнсэнд ордоггүй хэсгийг экспортолдог байна. Мал амьтны ясаар олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой бөгөөд түүхий эдийн нөөц нь харьцангуй тогтвортой байдаг. Гол асуудал нь нийт хаягдал яс, хэрэгцээгүй өөхний дийлэнх хувийг эзэлдэг өрхийн хэрэглээнээс гарч буй яс, өөхний цуглуулалтыг хэрхэн хийх асуудал манай улсын хувьд шийдэхэд төвөгтэй асуудал юм. Энэ нь иргэдийн хог ангилан хаях сэтгэхүй, нөхцөл боломж бүрдээгүй, хоёрдогч түүхий эдийн бүтээгдэхүүний логистик, нэгжийн зардал өндөр байх зэрэгтэй холбоотой байх нь дамжиггүй. Иймд одоо үйл ажиллагаа явуулж буй хаягдал яс дахин боловсруулах чиглэлийн үйлдвэрүүд түүхий эдээ Нарантуул зах, Хүчит шонхор, Хархорин зах болон Дархан, налайх, хотын мах боловсруулах үйлдвэрүүдээс гэрээ байгуулан авч байгаа. Мөн сүүлийн жилүүдэд мал нядлах, мах боловсруулах үйлдвэрүүд нэмэгдэж байгаа бөгөөд тэндээс гарах ясны хаягдлыг энэхүү үйлдвэр байгуулагдсанаар бүрэн боловсруулах боломжтой юм. БНХАУ-д Хаягдал яс боловсруулах 1 үйлдвэр сард дунджаар 4,800 тн яс боловсруулах хүчин чадалтай боловч тухайн орчинд нь хаягдал яс төдийлөн элбэг олдоггүй. Харин манай улс сард дунджаар 8,000 тн малын ясыг хог болгон хаядаг.

Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц

- *Усан хангамж:* Гүний худгаас хангана;
- *Бохир ус зайлуулах:* Зориулалтын ёмкость хуримтлуулаад тогтмол соруулна;
- *Цахилгаан хангамж:* Бага оврын дизель генератор суурилуулна;
- *Дулаан хангамж:* Цахилгаан тениэр халаана;

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Газрын гадаргуу: Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсаар хүрээлэгдэнэ.

Богдхан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн 40 орчим км үргэлжилсэн нуруу юм. Хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268 м өндөрт орших Цэцээ гүн юм. Тус ууланд 2000 метрээс дээш өргөгдсөн эртний тэгшрэлийн гадарга голлоно.

Хотын баруун хойд хэсэг нь 1831 м өндөр бүхий Толгойт, 1800 м өндөр бүхий Чингэлтэйн салбар уулсаар хүрээлэгдэнэ. Эдгээр уулс нь харьцангуй мөлгөр оройтой бөгөөд өвөр хажуу нь аажим намссаар Мааньт, Тасганы овоо, Нарангийн толгодорхог гадаргууд шилжиж үнэмлэхүй өндөр нь багасаж улмаар Туул голын хөндийн хэсэгт тулж очдог. Хотын баруун талд тектоник-дендуцийн гаралтай 1652 м үнэмлэхүй өндөртэй Сонгинохайрхан, Дарцагт, 1520 м өндөр Баян-Өндөр, Майхан толгой, Соёлд уул, Таширын нуруу, Улаан Ямаат, 1691 м өндөр Тахилт уулууд, зүүн талд 1527 м үнэмлэхүй өндөртэй Баянзүрх уул оршино.

Эдгээр уулс нь эгц хажуутай, хурц шовх оройтой, гарш хяруудыг үүсгэсэн байдаг. Дээрх өндөр уулсын муж болон уулс хоорондын хөндийн газрын гадаргын харьцангуй өндөршлийн зөрүү ихэвчлэн 400-500 м боловч заримдаа 700-920 м хүрдэг.


Туул голын хөндийн ай савын татмын үнэмлэхүй өндөр 1250-1345 м бөгөөд өргөний хэмжээ 1.2-4.0 км байдаг.

Толгойт, Баянхошуу, Баянцогт, Хойд Баян, Цагдуулт зэрэг нам уулсын мужийн үнэмлэхүй өндрийн хэмжээ 1515-1831 м ба тэдгээрийн хажуу ташлаг, энгэр, бэлийн налуу ихэвчлэн 15-20 хэм зарим тохиолдолд 30-35 хэм байдаг. Нэлээд өндөр өргөгдсөн уулсын мужийн хажуу ташлаг, энгэр, бэл, хормойг хөндлөн хэрчсэн олон тооны хуурай сайр, гуу жалга ховил түгээмэл ажиглагддаг.


Улаанбаатар хотын ихэнх барилга байгууламж нь Туул голын хөндийн ай сав болон Сэлбэ голын адаг хэсэг, Зүүн, Баруун Наран, Цагаан хуарангийн дэнжид тархжээ. Түүнчлэн, Туул голын хөндийн өмнөд жигүүрт Их, Бага тэнгэрийн аманд төр, засгийн тусгай объектууд тодорхой хамгаалалтын бүсэд оршдог.

Үүний зэрэгцээ Сэлбэ, Хөл, Бэлхийн голын хөндий, Туул голын Дээд Хар усан тохой, Могойн дэнж, Их Хуандай, Улиастай, Гачууртын голын адаг, Толгойтын голын Зүүн, Баруун салаа орчмоор хувийн орон сууцны зориулалттай бэсрэг цогцолбор, зуслангийн барилга байгууламж, гэр хорооллын объектууд нэлээд шигүү хэлбэрээр байрлаж байна (Эко Трейд ХХК, 2006).

Төслийн талбай район далайн түвшнээс дээш 1343.3 метрийн үнэмлэхүй өндөрт байрлаж, газрын гадаргын налуу буюу хэвгий 4.10 (градуст) байна.



Зураг 6. Төслийн талбайн районы д.т.д өндөршлийн зураг (метр)




Зураг 7. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)

Улаанбаатар хотын уур амьсгалын горим: Улаанбаатар хот нь ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м өндөртэй Богд-Хан, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Баянзүрх уулын дунд Туул голын хөндийд байрладаг (Даваадорж. Д, 2020). Ерөнхийдөө өвөл нь удаан (цас их унана), зун нь богино (аагим халуун, хур тунадас ахиухан ордог ч үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хавар, намар хүчтэй шуургатай өдөр тохиолддог.

Бид Улаанбаатар хотын уур амьсгалыг тодорхойлохдоо далайн түвшнээс дээш 1300 м орших “Улаанбаатар” цаг уурын станцын 1969-2019 оны хоорондох олон жилийн агаарын температур, хур тунадас, салхины хурд гэсэн статистик үзүүлэлтүүдийг ашиглалаа.

Улаанбаатар станцын дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур -0.3°C байгаа нь агаарын температурын хувьд сэрүүвтэр ойт хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд өвлийн улиралд -21°C , зуны улиралд $+19.3^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ. Агаарын температурын жилийн амплитуд дунджаар 23.7°C орчим байна.

Агаарт цочир хүйтрэх анхны дундаж хугацаа 9 дүгээр сарын 3-р арав хоногт байх ба хамгийн эрт нь 9 дүгээр сарын 1-р 10 хоногт байна. Харин эцсийн хүйтрэлт дунджаар 6 дугаар сарын эхний 10 хоногт, хамгийн хожуу нь 6 дугаар сарын 2-р 10 хоногт тохиолдож, цочир хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа дунджаар 137 хоног байна.



Зураг 8. Улаанбаатар хотын уур амьсгалын горим


Хаврын саруудад орох тунадасны хэмжээ аажмаар ихэссээр 5 дугаар сард ихсэж хамгийн их хур тунадас 7 сард 75.1 мм, намар 9 дүгээр сараас хур тунадасны хэмжээ огцом багсааж, 11 дүгээр сараас өвлийн гормондоо шилжиж 1 сард хамгийн бага хур тунадас буюу дунджаар 2.4 мм унадаг байна. Хоногт хэт их бороо орох, өвөл цас их унаж, хавар огцом дулаарах нь гэнэтийн үер болоход хүргэж, хөрсний эвдрэлийг ихэсгэж, зам, харилцаа, барилга, байгууламжид хор хөнөөл учруулдаг. Анхны цас дунджаар 9 дүгээр сарын 3-р 10 хоногт унах бөгөөд 11 дүгээр сарын дундаас цасан бүрхүүл тогтож, 100 орчим хоног цасан бүрхүүлтэй байж 4 дүгээр сарын эхээр цас хайлж, 5 дугаар сарын эхэн гэхэд дуусна. Сүүлчийн цас хожуудаа 5 дугаар сарын дунд арав хоногт ажиглагддаг. Цасны зузаан 2-4 см байх ба зарим хунгарласан газраа хааяа 10-20 см хүрдэг. Цасны нягт $0.16-0.30 \text{ г/см}^3$ байдаг.

Жилийн нийлбэр хур тунадас дунджаар 248 мм унадаг үүнээс дулаан улирлын нийлбэр хур тунадас 220мм буюу 89%, харин хүйтний улирлын нийлбэр хур тунадас 28мм буюу 11% ноогдох бөгөөд хур тунадасны хэмжээгээр хээрийн бүсэд хамрагддаг болохыг харуулж байна. Энэ бүс нутагт газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ

зэргээс хамаарч агаарын чийгшил өвөл, зун (1 ба 8 дугаар сард) хамгийн их, хавар намар (4 ба 10 дугаар сард) хамгийн бага болох ба жилийн дундаж утга нь 58,6% байна.


Салхины горим

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт салхины хурд олон жилийн дунджаар 2.4 м/с байдаг нь цаг агаар тогтуун бус бүс нутаг юм.



Зураг 9. Салхины хурдны жилийн явц


Салхины хурдны жилийн явцаас харахад хамгийн их болон хамгийн бага утга нь тус бүр хоёр, хоёр тохиож байна. Үндсэн хамгийн их утга нь 5 сард дунджаар 3.3 м/с, хоёрдугаар их утга нь 9 сард дунджаар 2.6 м/с ажиглагдсан бол үндсэн хамгийн бага утга нь 1 сард дунджаар 1.2 м/с, хоёрдугаар бага утга нь 7 сард дунджаар 2.7 м/с тохиодог байна.



Зураг 10. Салхины зүгийн давтагдал улирлаар (НЗДТГ, 2018)

Улаанбаатар станцын салхины зүгийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй жилд дунджаар баруун хойд зүгийн салхи 47.3 %-ийн давтагдалтай зонхилох боловч зүүний салхи 15.9 % байгаа нь зэргэлдээх зовхисоосоо

хавьгүй их давтагдалтай байна. Ялангуяа намар болон өвлийн улиралд энэ зүгийн салхи 13.0-14.3 % болж зонхилох зүг болдог. Энэ зүгийн салхины давтагдал хаврын сүүл сард нэлээд буурах боловч зуны саруудад ахин нэмэгддэг (НЗДТГ, 2018).



Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн өөрчлөлт


1969-2019 оны олон жилийн явцаас харахад жилийн агаарын дундаж температур ойролцоогоор 2.5°C -аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор тасралтгүй нэмэгдсээр буй нь Зураг 11-т харагдаж байна.

Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 1969 онд -2.58°C удаах хүйтэн жил -2.0°C байсан бол хамгийн дулаан жил 2007 онд 1.95°C хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтийн хандлагаас үзвэл өссөн болон буурсан тодорхой хандлага илрээгүй бөгөөд хур тунадасны хэмжээ 166,2-395,6 мм-ийн хооронд хэлбэлзсэн ба 1966-1981, 1994-2007 онд буурч 2007 оноос эхлэн өсөх хандлагатайгаар өөрчлөгдсөн байна.

Ус зүй: Төслийн талбай байрлах бүс нутаг нь Хойд мөсөн далайн ай сав, Туул голын сав газарт багтана.

Туул гол нь 6 дугаар эрэмбийн гол. Хан Хэнтий нурууны Бага Хэнтий сарьдгийн өврийн салбар уулсаас эх авах Номин гол, Шороотын даваа (1918 м)-ны өвөр, Шар булгийн сарьдаг (2542 м)-ийн салбар уулсаас эх авах Шороотын давааны өврийн голын бэлчрээс Туул хэмээн нэрлэгдэнэ. Голын ус хурах талбай 48868.4 км^2 , урт нь 871 км, хэвгий 0.0021. Голдрилын дундаж өндөр 1160 м, ус хагалбарын шугамын урт 2055.6 км, түүний дундаж өндөр 1719.0 м, голын сүлжээний нягт бага 0.16 км/км^2 , ус хураах талбайн дундаж өндөр 1300.0 м, хөндийн гүн дунджаар 559.0 м, ус хураах талбайн дундаж өргөн 56.1 км, сав газрын суналын зэрэг хамгийн их 16.5, ус хагалбарын шугамын тахиршлын зэрэг 2.6, хажуугийн хэрчигдэл бага 0,58, Хортгор-Страхлерийн хуулиар голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.2, 3.05, 5.572 тус тус байна. Энэ голын савд 1 дүгээр эрэмбийн сайр-горхи 1226, тэдгээрийн дундаж урт 2.3 км, ус хурах дундаж талбай 6.3 км^2 , 2 дугаар эрэмбийн горхи 320, 3 дугаар эрэмбийн гол 64, 4 дүгээр эрэмбийн гол 14, 5 дугаар эрэмбийн гол 4 байна. Хэнтий нурууны салбар уулсаас эх авах Галттай, Хийдийн гол, Хаг, Хонгор, Зүүн ба Баруун Баян, Заан, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол, горхи Туул голд цутгана.

Төслийн талбайн зүүн урд зүгт ойролцоогоор 4.0 км зайд Туул гол урсаж байна. Төслийн үйл ажиллагаанаас гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй байна..



Зураг 12. Төслийн талбайн районы гадаргын усны зураг

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих газар нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн мужийн Хэнтийн баруун хэсгийн 39-р тойргийн (Үндэсний атлас, 2009) нутгийг хамран байрлах бөгөөд хотжилт, гэр хорооллын нөлөөгөөр Хот суурины эвдэрсэн хөрс болон өөрчлөгдсөн байна (“Монгол орны хөрсний дижитал зураглал, хөрсний шинэчилсэн ангилал” сэдэвт ажлын тайлан, 2014). Дамбадаржаа орчмын Билгэхийн голын хөндий хэсгээр аллювийн ширэгт бараан хөрс болон аллювийн сайргархаг хөрсүүд бүрдэл байдлаар тархдаг байсан ба сүүлийн жилүүдийн хүн амын төвлөрөл, гэр хорооллын айл өрхүүд нэмэгдсэний нөлөөгөөр хөрсөн бүрхэвч эвдрэл, доройтолд орж байгалийн унаган төрхөө бүрмөсөн алдсан тул хөрсний шинэчилсэн ангиллаар Хот суурины эвдэрсэн хөрсний ангилалд багтах болсон. Одоогийн байгаа хот суурины эвдэрсэн хөрс нь ялзмагт үе давхаргагүй болж зулгарсан, ургамалгүй, халцгай байх ба хөрсний дээжийг өнгөн үеийн 0-10 см гүнээс авсан.

Ургамлын нөмрөг: Төслийн талбайн районд хялгана-хиаг-алаг өвст бэлчээрийн хэв шинжтэй, га-гийн ургац 0.1 цн/га. Энэхүү бүлгэмдлийн ургамлын ерөнхий тусгаг бүрхэц 10 %, ургамлын зүйлийн тоо 10 м² талбайд 1-2, 1 м² талбайд 1, үетэн 5 % зонхилж, алаг өвс (*Filifolium sibiricum* (L.) Kitam.) мөлхөө хиаг (*Agropyron repens* (L) P.B), улалж (*Carex stenophylloides* V. Krecz), татанхай шарилж (*Artemisia xanthochroa* Krasch), хавьсгана (*Scorzonera divaricata* Turcz), буган зогдор улалж (*Carex pediformis* C.A.Mey), налчгар хошуу (*Sibbaldianthe adpressa* Bge.), ерхөг (*Agropyron cristatum*), ширүүн хазааргана (*Cleistogenes squarrosa* Trin), жижиг навчит боролзгоно (*Dasiphora parvifolia* Fisch), навтуул гичгэнэ (*Potentilla acaulis* L), хигмэл гичгэнэ (*Potentilla multifida* L), ахарнавчит хунчир (*Astragalus brevifolius*), дунд таван салаа (*Plantago media* L), агь (*Artemisia frigida* Willd), маралхай шарилж (*Artemisia tanacetifolia* L) зэрэг ургана.

Ан амьтан: Нийслэлийн ногоон бүс, түүний орчмын уулсаар экологийн олон янзын орчинд амьдардаг 17 зүйлийн хөхтөн амьтан, 82 зүйл шувуу бүртгэгджээ. Амьтны хувьд бүтээн байгуулалт, хүн амын нягтралаас үүдэн зүйл болон тоо толгой жилээс жилд цөөрч байгаа. Нийслэл хот орчмын шувуудыг тоо толгойн байдлаар авч үзвэл элбэг буюу олон тоогоор байнга тааралддаг 8 зүйл, ердийн буюу түгээмэл тааралддаг 31 зүйл, тоо толгой элбэг бус ховор 21 зүйл, цөөн тоогоор буюу нэн ховор 22 зүйл шувуу байдаг юм байна. (Нийслэлийн байгаль орчны төлөв байдал, 2011, хуудас 108-112). Дүүрэг тус бүрээр нь зэрлэг амьтан болон шувуудын нарийвчилсан судалгаа одоогоор байхгүй байна.

Бидний судалгаа хийсэн “Монгол Нью Ресурс Технологи” ХХК-ийн “Хаягдал яс, өөх болон дайвар боловсруулах үйлдвэр”-ийн төслийн талбай нь Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутагт байрлана. Энэ хороо нь гэр хорооллын бүсэд байршилтай учраас зэрлэг амьтан байхгүй. Харин барилга байгууламж, суурин газрын 5 зүйл шувууд тодруулбал хэрэний төрлийн алаг шаазгай, улаан хошуут, хар хэрээ, тагтаа, бор болжмор элбэг байна.

Сонгинохайрхан дүүргийн 32-р хороонд суурьшлын бүстэй учраас шувуунаас өөр зэрлэг амьтан байх нөхцөл, орон зай байхгүй байна.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Монгол Улсын Их Хурлын 18 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 100 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй анхны хуралдааныг 1992 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр хийжээ. Анхны

хурлаас нийслэлийн Сонгинохайрхан дүүргийг 1992 оны 10 сарын 1-ний өдөр байгуулах тогтоол гарсан байна. Тус дүүрэг нь анх байгуулах тогтоол гарсан байна. Тус дүүрэг нь анх байгуулагдахдаа Сонгино нэртэй байв. Улмаар 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 39 тоот “Дүүргийн нэрийг өөрчлөх тухай” тогтоолоор Сонгинохайрхан дүүрэг болгон өөрчилжээ.

Уг нэрийг нийслэл хотын баруун талд орших Сонгино хайрхан уулын нэрээр нэрлэсэн юм. Энэхүү уулын оргил нь далайн түвшнээс 1663 метр өндөр.

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтөөр ийнхүү Нийслэлийн Октябрь район буюу одоогийн Баянгол дүүргээс өрх тусгаарлан байгуулагджээ.

Сонгинохайрхан дүүрэг 43-н хороотой 341 орчим мянган хүн амтай нийслэлийн хамгийн том газар нутагтай дүүрэг юм.

Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо: Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо нь нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6/48 тоот тогтоолоор 32 дугаар хороо болон зохион байгуулагдсан.

Тус хорооны Засаг даргаар В.Сүхбаатар, зохион байгуулагч Д.Саранцацралт, хөгжлийн нийгмийн ажилтан Б.Батцэцэг, улсын бүртгэлийн ажилтан Б.Хулан, халамжийн мэргэжилтэн Э.Даваахүү нар ажиллаж байна.

Бордоо, Баруун түрүү, 384 гарам, Эмээлт, Хурган зэрэг 5 хэсэгтэй тус хорооны 1 дүгээр хэсэг ахлагч Ц.Гэрэлтуяа нь 137 өрх, 2 дугаар хэсгийн ахлагч Г.Адилбиш 76 өрх, 3 дугаар хэсгийн ахлагч М.Оюунчимэг 180 өрх, 4 дүгээр хэсгийн ахлагч Нямсүрэн 184 өрх, 5 дугаар хэсгийн ахлагч И.Төмөрбаатар 86 өрхтэй хэсгийн ахлан ажиллаж байна.

Тус хороонд “Улаанбаатар буян” ХХК, Сонгинохайрхан үйлчилгээний төв, “Цэцэн хүү”, хүүхдийн цэцэрлэг зэрэг 72 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Хорооны “Жаргал өлзий” өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нар жилд давхардсан тоогоор 3500 гаруй хүнд эмнэлгийн анхан шатны үйлчилгээг хүргэж байна.

Эрхэм зорилт: Нийслэлийн дэд хөтөлбөр нийслэл, дүүргийн Засаг даргын 2016-2020 оны бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нийгэм эдийн засгийн зорилтыг хангах, 2020 онд дэвшүүлсэн “Нэг хот-Нэг стандарт” зорилтыг хангах, төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах төрийн үйлчилгээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

Зорилт: Төрийн хууль тогтоомж, бодлого шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, биелэлтийг хянах ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг үр дүнтэй өгөөжтэй болгон ил тод байдлыг хангаж, иргэдийн оролцоонд тулгуурласан хөгжлийн төлөө ажиллана.

ААН байгууллагууд: Тус хороонд Монгол мах экспо, Нефть бааз, Магнай Трейдийн агуулах, Буян холдинг, Улаанбаатар импекс, Монос фарм, Монос дээд сургууль, Олимд дээд сургууль, Хүнс трейд, төв цэвэрлэх байгууламж, Монгол транс, Зэвсэгт хүчний 013 дугаар анги, Зэвсэгт хүчний 150 дугаар анги, Хан богд кашмир ХХК, Мон фияа ХХК зэрэг аж ахуй нэгжүүд, Энхжин, Босса, ТНТ, Номин агуулах зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай 60 гаруй аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулдаг.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 3. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт			х							
Гадаргын урсцын өөрчлөлт			х							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х					х
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х					х
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			х							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			х							
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг			х							
Бэлчээрийн байдал			х							
Эрдэс түүхий эдийн нөөц			х							
Эрчим хүчний нөөц			х							
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар, хэмжээ			х							
Гадаргын усны чанар хэмжээ			х							
Агаарын бохирдол			х							
Хөрсний бохирдол			х							
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			х							
Дуу чимээ, шуугианы нөлөө			х							
4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			х							
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			х							
Тусгай хамгаалалттай газар нутагт			х							

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Будаж нөлөөлөх	Будалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x							
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			+
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			+
7. Бусад нөлөөлөл										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x							
Дүн	7	3	20	0	11	0	5	0	2	10

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө.

Шууд бус нөлөөлөл:

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө.

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт орших “Монгол Нью Ресурс Технологи” ХХК-ийн “Хаягдал яс, өөх болон дайвар боловсруулах үйлдвэр” төслийн 5 жилийн БОМТ-г БОУАӨЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийг баримтлан боловсруулсан болно.

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх.

Хүснэгт 4. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Ажлын нэр	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1,200.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,200.0
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,000.0
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	641.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
8	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт дүн		4,041.0

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУРУУЛАХ ХАМГААЛАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Агаарын бохирдол үүсэх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Төслийн талбайд	Тогтмол	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016
2	Авто тээврийн хэрэгслээс хорт хий ялгарах, дуу чимээ тархах	Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж буй машин техникийг үзлэг, оношилгоонд тогтмол оруулж, засвар үйлчилгээг шаардлагын дагуу хийж гүйцэтгэж байх	Үйлдвэрийн машин	Жилд 1 удаа	100.0	Жилд 1 удаа	100.0	2026 он	
Дүн							100.0		
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
4	Усан орчин бохирдох, Усны нөөц хомсдох	Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	Ширхэг	-	1 удаа	100.0	2026 он	“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль MNS 6561:2015 MNS 4943:2015 MNS 6734:2018 “Усны тухай хууль” БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан тушаал-А-230/127 тоот журам “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
5		Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/	Иж бүрэн	Ширхэг	Үйлд ажиллагааны зардал			2026 он	
6		Ус бохирдуулсны төлбөр төлөх	Хаягдал бохир усны цооног	Удаа	120.0	Жилд 1 удаа	120.0	2026 он	
7		Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Төслийн талбай	Удаа	Үйлд ажиллагааны зардал			2026 он	
8		Цэгийн орчны газрыг тэгшилж, хур борооны ус, чийг шүүрч нэвчихээс сэргийлж гадаргын урсац зайлуулах суваг татах	Бохир ус зайлуулах цооног, түүнээс үүсэх	м	500.0	1	400.0	2026 он	БОУАӨЯ-ны сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
13		Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.	бохирдлыг хязгаарлах	Улиралд 1 удаа	150.0	1	150.0	2026 он	
Дүн							770,0		
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
15	Хөрсний бохирдол	Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах	Төслийн талбай	Тухай бүр	-	Орчны тохижилт нөхөн сэргээлтийн хөтөлбөрт тусгасан		2026 он	MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”
		Авто зогсоолыг хатуу хучилттай болгох	Төслийн талбай	м²	-	-	180.0	2026 он	
16		Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх	Төслийн талбайн хөрс	удаа	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан		2026 он	
17		Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал			2026 он	
Дүн							180,0		
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
18	Ургамал	Сул чөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх зөвлөмж	Төслийн талбай	удаа	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ тусгагдсан			2026 он	Нөхөн сэргээлтийн аргачлал Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай
19		Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих	Төслийн талбай	га	Үйл ажиллагааны зардал			2026 он	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
20	Амьтан	Цахилгаан дамжуулах шугамын шувуунд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	Төслийн талбайн цахилгааны шугам	ширхэг	150.0	1	150.0	2026 он	Амьтны тухай хууль
Дүн							150.0		
Нийт дүн							1,200.0		

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Монгол Нью Ресурс Технологи” ХХК нь тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж бүхий нийтийн мод тарих үндэсний өдрөөр Нийслэлийн Байгаль орчны газраас санал болгосон газарт нийт 100 ширхэг Хайлаас, Голт бор мод тарина.

Хүснэгт 6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Хайлаас, Голт бор	Төслийн талбайд мод бут тариална., шар хуасан хашаанд	м ²	100	1,200.0	2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Нийт дүн						1,200.0		

БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллана.

Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал,төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	-	Тухайн үед нь шийдэх	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд

БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	Иж бүрэн	1 удаа	500.0	500.0	2026 он	БОУАӨЯ-ны сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль
2	Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх	Төвийн ойр орчмын 100 м-т	Тогтмол	Үйл ажиллагааны зардал			2026 он	
3	Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Төслийн талбайд	Иж бүрэн	1 удаа	450.0	450.0	2026 он	
4	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Дахин ашиглагдах хог хаягдал	Тогтмол	Үйл ажиллагааны зардал			2026 он	
5	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хог хаягдлын цэгт	Тогтмол	Улиралд 1 удаа	50.0	50.0	2026 он	
6	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх	Үйлдвэрийн ажилчдад	Удаа	Үйл ажиллагааны зардал			2026 он	Засгийн газрын 116 тогтоол
7	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх	Төслөөс үүсэх хог хаягдал	Удаа	Үйл ажиллагааны зардал			2026 он	
Нийт дүн						1,000.0		

БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажилчид	Жилд 1 удаа	24 хүн	Гэрээний үнийн дүнгээр		2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2	Олон нийт, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл	Ажлын идэвхтэй талбайг тойруулан хангалттай/зохистой гэрэлтүүлж, гэрэл цацруулагч саад тавих;	Төслийн талбай	Иж бүрэн	1	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
3		Ажиллагсдыг ХАБЭА -н хувцас хэрэгсэл буюу бээлий, малгай, хормогч, маск, хошуувч, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх;	Төслийн бүх ажилчид	Иж бүрэн	Жил бүр	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	MNS 5002:2000, “ХАБЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”
4		Төслийн бүх ажилчдад өдөр бүр ажил эхлэхээс өмнө ХАБЭА -н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХАБЭА -н зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох		-	Өдөр бүр	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
5		Төслийн хүрээнд ашиглагдах техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих	Иж бүрэн	Иж бүрэн	Өдөр бүр	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	MNS ISO 13688:2000, “ХАБЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” MNS 5390:2004, “ХАБЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
6		Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, Анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг хяналтын өрөө эсвэл ажлын байруудын аль тохиромжтой газар байрлуулах	Төслийн бүх ажилчдад	Удаа	Тухай бүр	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
7		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Төслийн талбай	Удаа	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
8	Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах	Ажилчдад	Жилд 1 удаа	24 хүн	Гэрээт ажлын дүнгээр		2026 он		


№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
9	Галын аюул гамшиг осол аюул	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж үйлдвэрийн доторх хананд байршуулах /Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох лоом, хүрз, сүх, хөрөө, хувин, хоолой, багор дэгээ, жоотуу, тармуур, хөөс, хорны суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланг зэргийг бэлэн байлгах./	Төслийн талбай	Тогтмол		Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
10		Онцгой байдлын газартай хамтарч гэнэтийн гал түймэр, гамшиг осолтой тэмцэх аргачилсан заавар зөвлөгөөг боловсруулж (ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөө) тусгах, өөрөөр хэлбэл авах ёстой арга хэмжээний дэс дарааллыг тодорхой тусгаж, хариуцах эзэнтэй болгох	Төслийн талбай	Тогтмол		ГҮД		2026 он	
11		Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах	Төслийн талбай	Иж бүрэн	Жилд 1 удаа	ГҮД		2026 он	
Нийт дүн						-			

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан мониторингийн цэгээс хөрс, ус, агаарын дээжийг тогтмол хугацаанд авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж. Байгаль орчны хяналт шинжилгээний тайлангийн үр дүнг жил бүрийн БОМТ-ний биелэлтийн тайланд тусгаж төсөл хэрэгжих сумдын багийн удирдлага болон нөлөөллийн бүсийн иргэдэд нээлттэй мэдээлж байх шаардлагатай.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар						
CO ₂ , NO ₂ , SO ₂ Тоос нийт (PM10, PM2.5) Дуу шуугиан хэмжээ	- Үйлдвэрийн байр дотор -1 цэг - 106°35'59.88"E 47°51'48.44"N - Үйлдвэрийн хашаан дотор -1 цэг - 106°35'57.45"E 47°51'42.83"N	Улиралд 1 удаа	1 цэгт	228.0	228.0	- MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн шаардлага
NO _x , SO ₂ , CO ₂ , TSP /нийт тоос/	- Усан халаалтын зуух - Яс шатаах байгууламж	Улиралд 1 удаа	1 цэгт	Гэрээний үнийн дүнгээр		- MNS 5919:2008 Уурын зуухны стандарт
Хөрс						
Хөрсний микробиологи Хөрсний хүнд металл	- Төслийн талбайн ил гарсан хөрснөөс - 106°35'58.00"E 47°51'41.86"N - 106°36'3.56"E 47°51'46.17"N	Жилд 1 удаа	1 цэгт	160.0	160.0	- MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх - MNS 5850: 2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай
Усны чанар						
Ерөнхий хими, Бактериологи	- Унд, ахуйн ус-1 цэг - 106°35'57.80"E 47°51'45.20"N	Жилд 1 удаа	1 цэгт	253.0	253.0	- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Нийт дүн					641.0	



Зураг 13. ОХИХ-ийн зураг

БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа хуваарь					Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Он						
			2026						
1	Төслийн хүчин чадал энэхүү тайланд тусгагдсанаас өөр нэмэлт өөрчлөлт орох бүрд дахин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай.	Тохиролцох						Үйлдвэрийн дарга	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 7.4, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам (Засгийн газрын 374 тогтоолын 2-р хавсралт)-ын 4.13- заалт
2	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Тохиролцох						Үйлдвэрийн дарга	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
3	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр						Үйлдвэрийн дарга	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
4	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг аймгийн байгаль орчны газарт хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	-	Жил бүр 12 сард					Үйлдвэрийн дарга, байгаль орчны ажилтан	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.12-р заалт, БОУАӨЯ-ны сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
Нийт		-							

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ.

Хүснэгт 12. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОУАӨЯ-нд	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүрийн 12-р сард	Төлөвлөгөө батлуулах	БОУАӨЯ-нд цахимаар илгээнэ
НБОГ-т болон цахимаар илгээнэ	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	Жил бүр 11-р сарын 1-ний дотор	Тайлан хянуулах	НБОГ-т болон цахимаар илгээнэ
Нийт дүн			-		